

**БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**С.БЯМБАЦОГТ**

## **ПРОКУРОРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Прокурорын тухай хуулийн төслийг боловсруулах дараахь хууль зүйн болон практик шаардлага байна. Үүнд:

#### **1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-д "иргэдээ аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах боломжоор хангах, хамтран ажиллахад төр онцгой анхаарах, хүний эрх, эрх чөлөөг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлж, энэ чиглэлд институци хоорондын уялдаа холбоог сайжруулна" гэж, 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т "Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш, шударгаар үйлчлэх эрх зүйн орчинг цогцоор нь бүрдүүлнэ" гэж, 2017 оны "Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай" 11 дүгээр тогтоолын хавсралтад "Прокурорын байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах" гэж, Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн 2010 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хурлаар дэмжсэн Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан "Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр"-т шүүх эрх мэдлийн хүрээний бусад оролцогч байгууллагын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг тус тус заажээ.

#### **1.2.Практик үндэслэл, шаардлага**

Улсын Бага Хурлын Тэргүүлэгчидийн 1930 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 25 дугаар тогтоолоор Улсын прокуроруудаас гүйцэтгэх эрх, үүргийн дүрэм нэртэйгээр анх Прокурорын байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндэс бүрдэж байжээ. Үүнээс хойш 1976 он хүртэл Шүүн таслах газруудын байцаагч нарын дагаж хэрэглэх заавар, БНМАУ-ын прокурорын байгууллагын дүрэм зэрэг эрх зүйн актуудад заасны дагуу үйл ажиллагаа явуулж байсан ба БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчидийн 1976 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 253 дугаар зарлигаар Прокурорын байгууллагын хууль батлагдан гарч Прокурорын байгууллагын эрх зүйн үндсийг анх удаа хуулиар тогтоосон байна.

1992 онд батлагдсан Үндсэн хуулийн үзэл баримтлал, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн Улсын Их Хурлаас 1993 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Прокурорын байгууллагын тухай хуулийг батлан гаргажээ.

Эрх зүйн тогтолцооны шинэчлэл, нийгмийн харилцааны өөрчлөлттэй холбоотойгоор 2002 онд Прокурорын байгууллагын тухай хуулийг шинэчлэн баталж мөрдүүлсэн нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд энэ хугацаанд уг хуульд 8 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Шүүх эрх мэдлийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр, Шүүх эрх мэдлийн байгууллагуудын шинэчлэл, нийгмийн харилцааны хувьсал, өөрчлөлт, эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгддэг гол хуулиудын шинэчилсэн найруулгын төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр боловсруулсантай холбогдуулан одоогийн мөрдөгдөж байгаа Прокурорын байгууллагын тухай хуулийг шинэчлэх, үзэл баримтлал, зохицуулалтыг өөрчлөх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Түүнчлэн Прокурорын байгууллагын тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлангийн зөвлөмж хэсэгт зөрчил, гэмт хэргийг шалгах, хянах, шийдвэрлэх ажиллагаа, ял эдлүүлэх ажиллагаа зэргийг зохицуулсан хуулиудын төсөлтэй нийцүүлэн Прокурорын байгууллагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг дурдсан байна.

Иймд дээр дурьдсан хууль зүйн болон практик шаардлагуудыг үндэслэн прокурорын байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим, Прокурорын байгууллагын тухай хуульд заасан зарим нэр томъёог оновчтой болгох, Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн эрүүгийн хууль тогтоомжийн төслүүдтэй уялдуулах, прокурорын байгууллагын харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг харьцуулан дүгнэж, үйл ажиллагааны хариуцлагатай байдлыг хангах, бусад байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн үндсийг бий болгох, прокурор үүргээ гүйцэтгэх нөхцөл баталгааг дээшлүүлэх, албан үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоо зэргийг тодорхой зохицуулсан Прокурорын тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулна.

### **Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т заасныг үндэслэн хуулийн нэр томъёог сайжруулах, зарим зүйл, заалтыг хүчингүй болгох, шинээр зүйл, заалт оруулах зэргээр хуулийн нийт заалтын тавиас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орж байгаа тул төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд уг хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараахь байдлаар тусгана. Үүнд:

### **Нэгдүгээр бүлэг**

Хуулийн төслийн зорилтыг тодорхойлж, үйл ажиллагаа удирдлагын үндсэн зарчим, прокурорын шийдвэрийг биелүүлэх зарчмыг зааж өгнө.

### **Хоёрдугаар бүлэг**

Прокурорын үйл ажиллагаа, прокурорын хяналт тавих, оролцох ажиллагаа, хяналт тавих арга, хэлбэрийг тусгана.

### **Гуравдугаар бүлэг**

Прокурорын байгууллагын эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, гэмт этгээд, хорих ял шийтгүүлсэн этгээдийг шилжүүлэх зэрэг олон улсын хамтын ажиллагааг хуульчилна.

### **Дөрөвдүгээр бүлэг**

Прокурорын хяналтын эрх зүйн хэлбэрийн төрлийг тодорхой тусгана.

### **Тавдугаар бүлэг**

Прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, бүрэлдэхүүн, тэдгээрийн эрх зүйн үндэс, бусад байгууллагатай хэрхэн харилцах асуудлыг зохицуулна.

### **Зургаадугаар бүлэг**

Прокурорын байгууллагын санхүүжилт, прокурорын чиг үүргээ хэрэгжүүлэх онцлогт тохирсон үйл ажиллагааны баталгааг хангах талаар тусгана. Ингэхдээ прокурорын байгууллагыг улсын төсвөөс санхүүжих, санхүүжилт нь тус байгууллага үүргээ шуурхай үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан байхаар зохицуулна.

### **Долоодугаар бүлэг**

Прокурорын мэргэжлийн болон сахилгын хариуцлагын талаар тусгахдаа Прокурорын мэргэжил болон ёс зүйн зөвлөлийн талаар зохицуулна.

### **Наймдугаар бүлэг**

Прокурорын байгууллагын бэлгэдэл, тамга, хэвлэмэл хуудас, прокурорын дүрэмт хувцас гэх мэт бусад асуудлын талаар зохицуулна.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар дараахь эерэг үр дүн гарна:

- Прокурорын байгууллагын тогтолцоо боловсронгуй болно;
- Хууль дээдлэх ёсны зарчимд нийцсэн ахиц дэвшил гарч, хүний эрх, эрх чөлөө хамгаалагдана;
- Прокурорын байгууллагад өгөх иргэдийн үнэлгээ өсч, тус байгууллага, иргэдийн хамтын ажиллагаа бэхжиж, үйл ажиллагааны чадавх дээшилнэ;

- Эрүүгийн хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх ажлын чанар, энэ чиглэлийн хууль хэрэгжүүлэх байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирна;
- Прокурор чиг үүргээ гүйцэтгэх нөхцөл, хууль зүйн болон эдийн засгийн баталгаа сайжирна.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой хэмжээний хөрөнгийг улсын төсвөөс нэмж санхүүжүүлэх шаардлагатай. Энэхүү хөрөнгийн зардлыг тусгайлан тооцож, төсөлд хавсаргана.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн тухай**

Прокурорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцсэн байна.

Уг хуулийн төсөлтэй уялдуулан Прокурорын байгууллагын тухай хуулийг хүчингүй болгох тухай хуулийн төслийг боловсруулна.

## **ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**